МОНГОЛ УЛСЫН eAIP

Монгол Улсын eAIP



Монгол улсын Нисэхийн Мэдээллийн Эмхэтгэл (НМЭ) гэдэг нь агаарын зай болон аэродромуудтай холбоотой хэд хэдэн хэвлэлийг нэрлэсэн ерөнхий нэршил юм.

Эдгээр баримт бичгүүд нь Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэхэд тавигдах дүрмийн болон агаарын зайн шаардлагуудыг тодорхойлсон байдаг.

НМЭ-д дараах зүйлс багтана:

Монгол Улсын НМЭ
(цахимаар, www.ais.mn)

НМЭ-ийн Нэмэлт

Агаарын навигацийн үйлчилгээний төрөл / хил хязгаар

Ил харагны илтгэх цэгийн зураг

Өнгөрөлтийн замын зургууд (IFR-т зориулсан).

NOTAM (Notices to Airmen) нь агаарын зай, аэродромуудад орсон өөрчлөлт, нислэгт нөлөөлөх аюул зэрэг яаралтай түгээх шаардлагатай мэдээллийг агуулна. НМЭ-ийг www.ais.mn/aipAip гэсэн вэб хуудсаараа зарлан нийтэлдэг.



Ил харааны илтгэх цэгүүд

Ил харааны нислэгт ил харааны илтгэх цэгийг ашигладаг. Хүчин төгөлдөр ил харааны зургуудыг Монгол Улсын eAIP www.ais.mn/aipAip хаягаар орж үзэж болно. Хүснэгтэд ил харааны цэгийн дуудлага, Туул голоос байрлах зай /км/, солбицол, тодорхойлолт /Remark/ зэргүүдийг харуулсан байдаг.

Нисгэгчид VFR-аар нисэхдээ, эсвэл IFR хирнээ ил харааны маневр хийх үедээ хамгийн сүүлийн үеийн ил харааны зургуудыг ашиглах ёстой.

Тэмдэглэл: 1. VFR нислэгээр “ЧИНГИС ХААН” ОУНБ-д буулт үйлдэх болон 2100 м-ийн түвшнээс нам өндрөөр АУБ-ны зооныг дайран өнгөрч нисэхээр бол АУБ-ны нислэгийн хөдөлгөөний удирдагчтай:

а) Зүүн зүгээс нисэн ирж байгаа бол “ҮЙЛДВЭР” илтгэх цэгийг:

б) Урд зүгээс нисэн ирж байгаа бол “СУУРИН” эсхүл “ЭЭЖ ХАД” (НМТ-ийн Туул ажлын байртай зөвшилцсөнөөр) илтгэх цэгийг:

в) Баруун зүгээс нисэн ирж байгаа бол илтгэх цэгийг тус тус нисэн өнгөрөхөөс өмнө холбоо тогтоосон байна.

2. “ЧИНГИС ХААН” болон “БУЯНТ-УХАА” АУБ хооронд 2100 м-ийн түвшнээс нам өндрөөр нисэх VFR нислэгийн НХУ-ыг “ӨЛЗИЙТ” болон “БУГАТ” илтгэх цэгүүдээр зөвшилцөн шилжүүлэн өгөх ба авна.

3. “АЛТАНБУЛАГ”, Сэргэлэн цэгүүд нь тус аэродромын буултын өмнөх чиг шулуунд ойр байршдаг тул доорх хязгаарлалтуудыг баримталбал зохино:

а) “АЛТАНБУЛАГ” илтгэх цэгийг “ЧИНГИС ХААН” ОУНБ-ын ХБЗ 11 буулт үйлдэх, ХБЗ 29 чиглэлээр баруун эргэлтээр нисэн гарах агаарын хөлөгтэй хугацааны болон чиглэлийн хувьд давхцах тохиолдолд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгжээс зөвшөөрөл олгосноос бусад тохиолдолд ашиглахыг хориглоно,

б) “СЭРГЭЛЭН” илтгэх цэгийг “ЧИНГИС ХААН” ОУНБ-ын ХБЗ 29 чиглэлээр буулт үйлдэх, ХБЗ 11 чиглэлээр нисэн гарах агаарын хөлөгтэй хугацааны болон чиглэлийн хувьд давхцах тохиолдолд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгжээс зөвшөөрөл олгосноос бусад тохиолдолд ашиглахыг хориглоно.

NOTE:

1. When VFR flight is to land at “CHINGGIS KHAAN” International Airport or fly over the aerodrome control zone at an altitude of 2100m or below, the pilot should make contact with the air traffic controller before passing the following points:

a) If flying in from the east, “UILDVER” reporting point;

b If flying in from the south, “SUURIN” or “EEJ KHAD” (coordination with “TUUL” of Flight Information Center) reporting point;

c) If flying in from the west, “ALTANBULAG” reporting point.

2. Transfer of control of VFR flight operating at the altitude of 2100m or below between “CHINGGIS KHAAN” and “BUYANT-UKHAA” aerodrome control zone is to be coordinated at “ULZIIT” and “BUGAT” reporting points.

3. “ALTANBULAG” and “SERGELEN” reporting points are located close to the runway touchdown zone, therefore the following restrictions should be adhered to:

a) It is prohibited to use “ALTANBULAG”reporting point in the case where the time and direction of an aircraft landing on RWY 11 and taking-off to the west from RWY 29 of “CHINGGIS KHAN” International Airport coincides, unless otherwise approved by the Air Traffic Control unit

b) It is prohibited to use “SERGELEN” reporting point in the case where the time and direction of an aircraft landing on RWY 29 and taking-off from RWY 11 of “CHINGGIS KHAAN” International Airport coincides. unless otherwise approved by the Air Traffic Control unit.

ZMCK/Chinggis Khaan
ZMUB/Buyant-Ukhaa

Visual REP



ARP
"**CHINGGIS KHAAN**" International Airport Control Zone 47°38' 49"N 106°49' 12"E

Call sign	BRG / DIST from ARP	Coordinate	Remarks
АЛТАНБУЛАГ ALTANBULAG	281°(T) / 32km	47°42'00"N; 106°24'26"E	Төв аймгийн "Алтанбулаг" сум Altanbulag soum, Tuv province
ЗУУНМОД ZUUNMOD	055°(T) / 12km	47°42'28"N; 106°56'58"E	Төв аймгийн "Зуунмод" хот Zuunmod city, Tuv province
ҮЙЛДВЭР UILDVER	108°(T) / 38km	47°32'29"N; 107°17'55"E	Үйлдвэрийн объект Factory Object
СЭРГЭЛЭН SERGELEN	105°(T) / 16km	47°36'40"N; 107°01'25"E	Төв аймгийн "Сэргэлэн" сум Sergelen soum, Tuv province
СУУРИН SUURIN	181°(T) / 15km	47°30'53"N; 106°48'56"E	Зам дагуу байрлах жижиг суурин Small settlement along the road
ЭЭЖ ХАД EEJ KHAD	162°(T) / 39km	47°18'44"N; 106°58'37"E	"Ээж хад" цогцолбор "Eej khad" complex

ARP
"**BUYANT-UKHAA**" International Airport Control Zone 47°50' 33"N 106°46' 03"E

Call sign	BRG / DIST from ARP	Coordinate	Remarks
БУГАТ BUGAT	142°(T) / 9km	47°46'31"N; 106°50'44"E	Хуучнаар Бугын сангийн аж ахуй Vicinity of the former deer farm
ӨЛЗИЙТ ULZIIT	214°(T) / 8km	47°47'05"N; 106°42'37"E	"Өлзийт" хороолол Ulziit Khoroolol
СОНГИНО SONGINO	250°(T) / 12km	47°48'19"N; 106°37'10"E	"Сонгино" уулын баруун урд бэл Southwest hillside of Songino Mountain
ЖИРЭМ JIREM	285°(T) / 40km	47°55'55"N; 106°15'05"E	"Жирмийн цагаан" нуур "Jirmiin tsagaan" lake
ДОЛООН ХУДАГ DOLOON KHUDAG	297°(T) / 21km	47°55'45"N; 106°30'41"E	Хүй 7-н худгийн цементэн тойргууд Cemented circle at the 7th khudag
РАШААНТ RASHAANT	331°(T) / 29km	48°04'15"N; 106°34'43"E	Төмөр замын Рашаант өртөө Railway "Rashaant" terminal
НАЙРАМДАЛ NAIRAMDAL	352°(T) / 20km	48°00'58"N; 106°43'51"E	Хүүхдийн Найрамдал зуслан Children's Camp
ЯАРМАГИЙН ГҮҮР YARMAGIIN GUUR	055°(T) / 9km	47°53'15"N; 106°51'51"E	Ярмагийн гүүр Yarmag Bridge

Ил харааны илтгэх цэгийн мэдээлэл ба зураг:
вэб: www.ais.mn
утас: 976-7128312

Тэмдэглэл: 2. VFR нислэгээр “БУЯНТ-УХАА” НБ-д буулт үйлдэх болон 2100 м-ийн түвшнээс нам өндрөөр АУБ-ны зооныг дайран өнгөрч нисэхээр бол АУБ-ны нислэгийн хөдөлгөөний удирдагчтай:

а) Зүүн зүгээс нисэн ирж байгаа бол “ЯАРМАГИЙН ГҮҮР” илтгэх цэгийг:

б) Хойд зүгээс нисэн ирж байгаа бол “РАШААНТ” болон “Найрамдал” илтгэх цэгийг;

в) Баруун хойд болон баруун зүгээс нисэн ирж байгаа бол “7-н ХУДАГ” болон “СОНГИНО” илтгэх цэгийг тус тус нисэн өнгөрөхөөс өмнө холбоо тогтоосон байна.

2. “БУЯНТ-УХАА” болон “ЧИНГИС ХААН” АУБ хооронд 2100 м-ийн түвшнээс нам өндрөөр нисэх VFR нислэгийн НХУ-Ыг “ӨЛЗИЙТ” болон “БУГАТ” илтгэх цэгүүдээр зөвшилцөн шилжүүлэн өгөх ба авна.

3. “ӨЛЗИЙТ”, “7-н ХУДАГ” цэгүүд нь тус аэродромын IFR буултын журмын өмнөх чиг шулуун болон хоёрдугаар тойрогт гарах замд ойр байршдаг тул доорх хязгаарлалтуудыг баримталбал зохино:

а) “ӨЛЗИЙТ” илтгэх цэгийг “БУЯНТ-УХАА” ОУНБ-ын ХБЗ 14 чиглэлээр буулт үйлдэх агаарын хөлөгтэй хугацааны болон чиглэлийн хувьд давхцах тохиолдолд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгжээс зөвшөөрөл олгосноос бусад тохиолдолд ашиглахыг хориглоно;

б) “7-н ХУДАГ” илтгэх цэгийг “БУЯНТ-УХААД” ОУНБ-ын ХБЗ 14 чиглэлээр буулт үйлдэх болон ХБЗ 32 чиглэлээр нисэн гарах агаарын хөлөгтэй хугацааны болон чиглэлийн хувьд давхцах тохиолдолд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгжээс зөвшөөрөл олгосноос бусад тохиолдолд ашиглахыг хориглоно.

NOTE:

1. When VFR flight is to land at “BUYANT-UKHAA” International Airport or fly over the aerodrome control zone at an altitude of 2100m or below, the pilot should make contact with the air traffic controller before passing the following points:

a) If flying in from the east, “YARMAGIIN GUUR” reporting point;

b) If flying in from the north, “RASHAANT” and “NAIRAMDAL” reporting point;

c) If flying in from the west or southwest, “7 KHUDAG” and “SONGINO” reporting point.

2. Transfer of control of VFR flight operating at the altitude of 2100m or below between “CHINGGIS KHAAN” and “BUYANT-UKHAA” aerodrome control zone is to be coordinated at “ULZIIT” and “BUGAT” reporting points.

3. “ULZIIT” and “7 KHUDAG” reporting points are located close to “BUYANT-UKHAA” International Airport’s Instrument approach procedure and missed approach procedure; therefore, the following restrictions should be adhered to:

a) It is prohibited to use “ULZIT” reporting point in the case where the time and the direction of an aircraft landing on RWY 14 of “BUYANT-UKHAA” International Airport coincides, unless otherwise approved by the Air Traffic Control unit.

b) It is prohibited to use “7 KHUDAG” reporting point in the case where the time and direction of an aircraft landing on RWY 14 and taking-off from RWY 32 of “BUYANT-UKHAA” International Airport coincides, unless otherwise approved by the Air Traffic Control unit.

ZMCK/Chinggis Khaan
ZMUB/Buyant-Ukhaa

Visual REP



"**CHINGGIS KHAAN**" International Airport Control Zone

ARP 47°38' 49"N 106°49' 12"E

Call sign	BRG / DIST from ARP	Coordinate	Remarks
АЛТАНБУЛАГ ALTANBULAG	281°(T) / 32km	47°42'00"N; 106°24'26"E	Төв аймгийн "Алтанбулаг" сум Altanbulag soum, Tuv province
ЗУУНМОД ZUUNMOD	055°(T) / 12km	47°42'28"N; 106°56'58"E	Төв аймгийн "Зуунмод" хот Zuunmod city, Tuv province
ҮЙЛДВЭР UILDVER	108°(T) / 38km	47°32'29"N; 107°17'55"E	Үйлдвэрийн объект Factory Object
СЭРГЭЛЭН SERGELEN	105°(T) / 16km	47°36'40"N; 107°01'25"E	Төв аймгийн "Сэргэлэн" сум Sergelen soum, Tuv province
СУУРИН SUURIN	181°(T) / 15km	47°30'53"N; 106°48'56"E	Зам дагуу байрлах жижиг суурин Small settlement along the road
ЭЭЖ ХАД EEJ KHAD	162°(T) / 39km	47°18'44"N; 106°58'37"E	"Ээж хад" цогцолбор "Eej khad" complex

"**BUYANT-UKHAA**" International Airport Control Zone

ARP 47°50' 33"N 106°46' 03"E

Call sign	BRG / DIST from ARP	Coordinate	Remarks
БУГАТ BUGAT	142°(T) / 9km	47°46'31"N; 106°50'44"E	Хуучнаар Бугын сангийн аж ахуй Vicinity of the former deer farm
ӨЛЗИЙТ ULZIIT	214°(T) / 8km	47°47'05"N; 106°42'37"E	"Өлзийт" хороолол Ulziit Khoroolol
СОНГИНО SONGINO	250°(T) / 12km	47°48'19"N; 106°37'10"E	"Сонгино" уулын баруун урд бэл Southwest hillside of Songino Mountain
ЖИРЭМ JIREM	285°(T) / 40km	47°55'55"N; 106°15'05"E	"Жирмийн цагаан" нуур "Jirmiin tsagaan" lake
ДОЛООН ХУДАГ DOLOON KHUDAG	297°(T) / 21km	47°55'45"N; 106°30'41"E	Хүй 7-н худгийн цементэн тойргууд Cemented circle at the 7th khudag
РАШААНТ RASHAANT	331°(T) / 29km	48°04'15"N; 106°34'43"E	Төмөр замын Рашаант өртөө Railway "Rashaant" terminal
НАЙРАМДАЛ NAIRAMDAL	352°(T) / 20km	48°00'58"N; 106°43'51"E	Хүүхдийн Найрамдал зуслан Children's Camp
ЯАРМАГИЙН ГҮҮР YARMAGIIN GUUR	055°(T) / 9km	47°53'15"N; 106°51'51"E	Яармагийн гүүр Yarmag Bridge

АГААРЫН ЗАЙ


“A” Ангилалын агаарын з
6150
TMA
“C” ангилалын
агаарын
4050
TMA
“C” ангилалын хяналтта
агаарын зай
3150
TMA
“C” ангилалын
хяналттай агаарын
зай
2100
CTR
CTR
“G” Ангилалын хяналттүй агаарын зай
Газарын гадрага



Тогтоогдсон агаарын зай

Агаарын зайн мэдээллийг Монгол Улсын НМЭ- ийн 2 дугаар бүлэг (ENR 2) “Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний агаарын зай” хэсгээс (www.ais.mn/ai-pAip) үнэ төлбөргүйгээр үзэх боломжтой. Тус вэб сайтад агаарын зайн координатууд болон бусад мэдээллүүд багтаасан байдаг.

Бүх тогтоогдсон агаарын зайд үсгэн тэмдэглэгээтэй тусгай тодорхойлогч болон нэр өгсөн байдаг. Монгол Улсын аэродромын орчмын агаарын зайн нь “CTR” “TMA” гэж үсэг тодорхойлогдоно.

Хяналттай аэродром “CTR Aerodrome Contol Zone”

Улаанбаатар хотын хувьд Буянт-Ухаа болон Чингис Хаан ОУНБ-ын Хяналттай аэродромд Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба аэродромын удирдлагын үйлчилгээ үзүүлдэг. Дээрх хоёр хяналттай аэродром нь хяналттай агаарын зай гэсэн үг юм.

Хяналттай агаарын зай

Хяналттай агаарын зайг заримдаа “мөөгөн хэлбэртэй” гэж нэрлэдэг (диаграммыг үзнэ үү). Хяналттай агаарын зай нь хоёр төрөл байна: аэродромын удирдлагын зоон (CTR 0м - 2100м) газрын гадаргаас дээш 2100м хүртэл; ойртолтын удирдлагын бүс (TMA) нь 2100м – 6150м хүртэлт.
Хяналттай агаарын зай дотор нислэгийн хөдөлгөөний удирдлага (ATC) нь агаарын хөлгүүдэд зааварчилга, зөвшөөрөл өгч аюулгүй зайчлахыг хангуулдаг.
Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний төрлүүдийн талаар 12-р хуудаснаас үзнэ үү.

Аэродромын

удирдлагын зоон

(Өндөр 0м – 2100м)



Буянт-Ухаа болон Чингис Хаан аэродромуудын удирдлагын зоонуудад (CTR) хөөрч, бууж эсхүл нэвтрэх НХУ-ын зөвшөөрлийг (ATC Clearance) Аэродромын удирдлагын цамхгаас өгнө. Мөн ATC нь IFR агаарын хөлөгт аль ил харааны ойртолт болон хөөрөлт үйлдэх зөвшөөрөл өгч болдог.

Аэродромын удирдлагын зоонд зориулсан VFR болон IFR нислэгийн журмууд боловсруулагдсан байдаг. Энэхүү нислэгийн журмын мэдээллийг Монгол Улсын НМЭ-ээс AD 2 Аэродромууд (www.ais.mn/aipAip) хэсгээс үзэж болно.

Ойртолтын
удирдлагын бүс



Caution: *Do not use SER VOR/DME radial between 304° to 070° (clockwise), beyond 25NM (46.3km) below 3800m AMSL.*

(Өндөр 2100м – 6150м)

Ойртолтын удирдлагын бүс (TMAs) нь тогтоосон доод хязгаараас тогтоосон дээд хязгаар хүртэл үргэлжилнэ.

TMA-н өөр өөр хэлбэртэйгээр өндрийн 3 шатлалтай тогтоогдсон байдаг. Үүнд:

- 2100м-3150м,
- 3150м-4050м,
- 4050м-6150м

АГААРЫН ЗАЙН АНГИЛАЛ

Монгол улсын агаарын зайг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын (ICAO) агаарын зайн ангиллын системийн дагуу ангилдаг. Энэхүү систем нь ямар түвшний нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ (ATS) үзүүлэх болон тухайн агаарын зайд нэвтрэхэд ATC / Clearance/ зөвшөөрөл шаардлагатай эсэхийг тодорхойлдог.

Дараах хүснэгтэд Монгол Улсад ашиглагдаж буй ICAO агаарын зайн ангиллыг, тэдгээрийн ашиглалтын хязгаарлалтын хамт харуулав.

ICAO-ийн агаарын зайн A-гаас G гэсэн 7 ангилал байдаг. Одоогоор Монгол Улсад A, C, D, G ангиллыг ашигладаг.

A ангиллын агаарын зай

Монгол Улсын Нислэгийн Мэдээллийн Бүс (FIR) дахь дээд өндрийн, олон улсын агаарын замуудыг багтаахын тулд A ангиллын агаарын зайг ашигладаг. IFR агаарын хөлгүүдийг бусад IFR агаарын хөлгөөс зайчилдаг. VFR нислэгийг энэ агаарын зайд оруулахыг хориглодог.

C ангиллын агаарын зай

C ангиллын агаарын зай нь: Монгол улсын томоохон аэродромуудын CTR болон TMA бүсэд ашиглагдана. Хяналтгүй агаарын зайгаас энэ бүсэд нэвтрэх зөвшөөрөл аэродромын удирдлагын цамхгаас заавал авна. Энэ агаарын зайд IFR болон VFR нислэгүүдийг бие биеэс нь байнга зайчилна. CTR дотор IFR агаарын хөлгүүдийг тусгай VFR (VMC-ээс бага цаг уурын нөхцөлд ажилладаг) нислэгээс, харин хараа 5 км-ээс бага үед тусгай VFR онгоцнуудыг бие биеэс нь зайчилдаг.

Зайчлал хангагдаагүй нөхцөлд, нислэгийн хөдөлгөөний удирдагчид VFR нислэгүүдэд бусад VFR-ийн талаар, эсвэл хараа 5 км-ээс бага үед тусгай VFR-ийн талаарх зохих нислэгийн хөдөлгөөний мэдээллээр

хангах шаардлагатай. Гэхдээ VFR нислэгүүд нь өөрсдөө хоорондоо зайчлалаа хангах үүрэгтэй.
Бүх агаарын хөлөг С ангиллын агаарын зайгаар дамжин нисэхэд ч мөн ATC зөвшөөрөл авах шаардлагатай.

D ангиллын агаарын зай

D ангиллын агаарын зай нь ихэвчлэн орон нутгийн аэродромуудыг тойрсон CTR, TMA-уудад байдаг. IFR нислэгүүд нь бусад IFR-аас зайчлагдана, харин VFR нислэгүүдийг IFR болон бусад VFR нислэгүүдээс зайчилдаггүй.

Зөвхөн CTR дотор, тусгай VFR нөхцөлийн үед, IFR агаарын хөлгийг тусгай VFR агаарын хөлгөөс, хараа 5 км-ээс бага үед тусгай VFR-ыг бусад тусгай VFR-аас тус тус зайчилдаг НХУ-ын зайчлал хангагдаагүй тул D ангиллын агаарын зайд нисэж байгаа VFR болон IFR агаарын хөлгийн нисгэгчид маш анхааралтай нисэж, хоорондын зайчиллаа барих хэрэгтэй.

C болон D ангилал ерөнхий

C болон D ангиллын агаарын зайд нисэхийн тулд нэвтрэх зөвшөөрөл авах шаардлагатай. Энэ нь тус агаарын зайд нислэг үйлдэх бүх агаарын хөлгийг нислэгийн хөдөлгөөний удирдагч мэдсэн байх шаардлагатай байдаг.
Нислэгийн хөдөлгөөний удирдагчид нэвтрэх зөвшөөрөл олгохоос дараах үндэслэлээр татгалзах боломжтой:

- Нислэгийн төлөвлөлт (Flight Plan)
- Агаарын хөлгийн байршлын талаарх мэдээлэл хангалтгүй байх
- Нислэгийн хөдөлгөөний удирдагч, нисгэгчийн хооронд 2 талын найдвартай холбоо тогтоогүй үед
- Хариуцлагын бүсэд нь байгаа агаарын хөлгийн тоо нислэгийн удирдагчийн хүчин чадалд тулсан
- Онцгой тохиолдлын үед

VFR хөлгийг агаарын зайд нэвтрэхийг саатуулах эсвэл татгалзах нь тодорхой үндэслэлтэй байх ёстой. Гэхдээ VFR нисгэгчид саатуулсан, татгалзсан шалтгаан болж буй нислэгийн хөдөлгөөний талаар заавал мэдэгдэх шаардлагагүй.

G ангиллын агаарын зай

Монгол Улсын FIR дотор бусад ангилал олгогдоогүй бүх агаарын зай нь G ангиллын агаарын зай болно. G ангиллын агаарын зайд нэвтрэх зөвшөөрөл шаарддаггүй. Гэхдээ та G ангиллын агаарын зайн дүрмийг дагаж мөрдөх ёстой. Маршрутын дагуу явж буй IFR болон VFR агаарын хөлөг нь CTR эсвэл TMA-ийн давтамжийг байнга сонсож байх ёстой (AIP Mongolia GEN 2.1-ийг үзнэ үү).

G ангиллын агаарын зайн аюулгүй ажиллагаа "хар, илрүүл, зайлсхий" зарчим дээр үндэслэнэ. Дүрэм 91-т заасан алсын хараа, газрын гадарга болон үүлнээс алслагдах хязгаарлалтуудыг баримтална.
IFR нислэг нь G ангиллын агаарын зайд IMC-д орох үед нислэгийн мэдээллийг заавал авсан байна. НХУ тухайн нутаг дэвсгэрт байгаа бусад IFR агаарын хөлгүүдийн талаарх нислэгийн хөдөлгөөний мэдээллийг дэлгэрэнгүй өгөх болно. Тус мэдээллийг үндэслэн нисгэгч бусад агаарын хөлгүүдээс хангалттай зайг өөрөө баримтлан нисэх үүрэгтэй.

Монгол улсад ашигладаг ОУИНБ-ын агаарын зай ангиллууд

A ангилал

Зөвхөн IFR нислэг зөвшөөрөгдөнө. Бүх нислэгт нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ үзүүлэх ба хооронд нь зайчилсан байна.

C ангилал

IFR болон VFR нислэг зөвшөөрөгдөнө. Бүх нислэгт нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ үзүүлэх ба IFR нислэгийг бусад IFR болон VFR нислэгүүдээс зайчилна. VFR нислэг нь IFR нислэгээс зайчлах ба бусад VFR нислэгийн талаарх нислэгийн хөдөлгөөний мэдээллээр хангагдана.

D ангилал

IFR болон VFR нислэг зөвшөөрөгдөнө. Бүх нислэгт нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ хангагдах ба IFR нислэг нь бусад IFR нислэгүүдээс зайчлагдаж, VFR нислэгийн талаарх нислэгийн хөдөлгөөний мэдээллээр хангагдана. VFR нислэг нь бусад бүх нислэгийн талаарх нислэгийн хөдөлгөөний мэдээллээр хангагдана

G ангилал

IFR болон VFR нислэг зөвшөөрнө. Хүсэлтийн дагуу нислэгийн мэдээллийн үйлчилгээг үзүүлнэ.

Ерөнхий зориулалтын нисэхийн бүсүүд

Ерөнхий зориулалтын нисэхийн бүсүүд (GAAs) нь тодорхой нөхцөлд G ангиллын (хяналтгүй) агаарын зай болж хувирдаг хяналттай агаарын зайн хэсэг юм. GAA-г зөвхөн өдрийн цагаар ашиглах боломжтой. GAA-ууд дотор сургалтын үйл ажиллагаа зэрэг зорилготой, хөдөлгүүртэй болон хөдөлгүүргүй (планер г.м) агаарын хөлгүүд нисдэг болохыг анхаарна уу.

Ерөнхий зориулалтын нисэхийн бүсийг дараах байдлаар ашиглана. Үүнд:

• Өдрийн цагаар.

Энэ төрлийн GAA-г ашиглахдаа АТС-д хүсэлт гаргах, мэдэгдэх шаардлагагүйгээр ашиглаж болно. Эдгээрийг VNC дээр “ӨДӨР” гэж тэмдэглэсэн байна.

• Заавал урьдчилан мэдэгдэх

Хяналттай агаарын зайн хилээр нэвтрэх болон дайран өнгөрөх зөвшөөрөл авна.

• Нислэгийн төлөвлөлт ба зөвшөөрлөөр

Нисгэгч тухайн агаарын зайд нислэг үйлдэхээс өмнө тодорхой хугацааны өмнө нислэгийн хөдөлгөөний нэгжид хүсэлтээ өгөх хэрэгтэй. Ингэснээр нислэгийн удирдагчид нислэгийн хөдөлгөөний удирдлагаа зохицуулах цаг гарах юм.

НХУ-ын зөвшөөрлийн дагуу идэвхэжсэн ерөнхий зориулалтын нислэгийн бүсэд нислэгийн удирдагч агаарын хөлгийг бүсэд нэвтрэх, гарах үед эсхүл тодорхой цагт илтгэх зааварчилга өгч болно. Мөн радио холбооны давтамжийг тасралтгүй сонсох зааварчилга өгөх нь ч бий. Хэрэв аливаа нэг зүйл тодорхой бус тохиолдолд нислэгийн удирдагчаасаа асуух нь зүйтэй.

Бусад агаарын хөлөг тухайн бүсэд нислэг үйлдэхийг хүсвэл тухайн бүсийг идэвхжүүлсэн нислэгийн хөдөлгөөний нэгжээс зөвшөөрөл хүсэх ёстой.

Ерөнхий зориулалтын нислэгийн бүсэд нисэхэд нислэгийн хөдөлгөөний нэгжид агаарын хөлгийг байршлыг тогтооход хялбар байх зорилгоор транспондер эсхүл ACAS-аар тоноглогдсон байхыг зөвлөдөг. Нислэгийн удирдагч өөр код өгөөгүй тохиолдолд, хөдөлгүүрт агаарын хөлөг транспондер дээрээ 1200, глайдер 1300 гэсэн код тохируулна.

Нислэгийн удирдагч IFR нислэг үйлдэж буй агаарын хөлгийн нисгэгч өөрөө хүсэлт тавьсан эсхүл ерөнхий зориулалтын бүсийн тухай мэдээллийг өгснөөс бусад тохиолдолд энэ бүсэд IFR нислэг үйлдэж буй агаарын хөлгийг нэвтрүүлэхгүй.

Тухайн бүсийг идэвхжүүлсэн нислэгийн хөдөлгөөний нэгж нь ажлын ачаалал бага үед энэ бүсэд нислэгийн хөдөлгөөний мэдээлэл, зөвлөмжөөр ханган ажиллаж болно. Гэхдээ энэ бүсэд агаарын хөлөг хооронд аюулгүйн зайчлал хангуулдаггүй гэдгийг санах хэрэгтэй.

Ил харааны навигацийн зураг дээр ерөнхий зориулалтын нислэгийн бүсийг G… гэж тэмдэглэдэг. Мөн ерөнхий зориулалтын нислэгийн бүсийн дээд хязгаар өндөр тохиолдолд навигацийн зургууд дээр тэмдэглэсэн байдаг.



Бага оврын агаарын хөлгийн хөөрч буух түр зурвас, талбай

Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх үүднээс түр зурвас, талбай сонгон тодорхой мэдээллийг архивласан байдаг.

Тус мэдээллийг Буянт-Ухаа Олон Улсын нисэх буудлын Аэродромын нэгжээс авч болно.

Доорх хаягаас хөөрч буух түр зурвас, талбайн мэдээллийг харж болно.

(www.mcaa.gov.mn/category/510)

Нисдэг тэрэгний зогсоол нь одоогоор НМЭ-д “Богд хан“ буюу Хан-Уул дүүргийн 15-р хорооны байршилд /22.5x22.5/ хэмжээтэй зарлагдсан байдаг. Дэлгэрэнгүй мэдээллийг (https://ais.mn/aipHeliport) хаягаар харж болно.



ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АГААРЫН ЗАЙ

Тусгай зориулалтын агаарын зайд дараах төрлийн агаарын зай хамаарна. Үүнд:

- Хязгаарлалттай бүс
- Цэргийн бүс /MOA/

Тусгай зориулалтын агаарын зай нь тухайн агаарын зайн ангиллыг өөрчлөхгүй. Тухайлбал D ангиллын удирдлагын зоон дахь нам өндрөөр нислэг үйлдэх бүс нь D ангиллынх байна. Харин удирдлагын зооноос гадна ийм бүс нь G ангиллын агаарын зайд тооцогдоно. Харин тухайн тусгай зориулалтын агаарын зайд мөрдөгдөх дүрэм журам, шаардлага нь үндсэн





Цэргийн бүс (МОА)

Нэрээс нь харахад л буудлага хийх, тэсрэх бодис ашиглах гэх мэт цэргийн үйл ажиллагаа явуулах бүс юм. Цэргийн бүс NOTAM мэдээгээр идэвхэжсэн үед нэвтрэх болон үйл ажиллагаа явуулах нь хориотой байдаг. Үүнд: Зарим цэргийн бүсийг идэвхжүүлсэн эсэхийг анхаарууштай. Өөрөөр хэлбэл зөвшөөрөлгүй агаарын хөлөг

ХҮНГҮЙ НИСЭХ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗОХИЦУУЛАЛТ






Эхлэх
Үйл ажиллагааны төлөвлөлт хийх
ИНД-101 эсвэл ИНД-102-г тодорхойлох
ИНД-101
ИНД-102
ИНД-101-ийн нөхцөлийг хангасан байдал
ИНЕГ-т мэдэгдэл хүргүүлэх
ИНЕГ хянан үзэх
Шаардлагтай тохиолболд нэмэлт материалыг хүргүүлэх
CAA 24102/01 маягтаар хүсэлт гаргах
Үйл ажиллагааны тодорхойлолт, Ерөнхий заавар боловсруулах
ИНЕГ хянан үзэх
Үгүй
Баримт бичигийн бүрдэл хангалттай юу?
Тийм
Гэрчилгээ олгох
Нислэгийн үйл ажиллагаа эхлүүлэх
Дуусгах

ХҮНГҮЙ НИСЭХ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗОХИЦУУЛАЛТ

ИНД-101-ийн хүрээнд хүнгүй агаарын хөлгөөр (дроноор) нислэгийн үйл ажиллагаа явуулах этгээд нь хэд хэдэн үндсэн шаардлагыг бүрэн хангаж Иргэний нисэхийн ерөнхий газраас тусгай гэрчилгээ авалгүйгээр үйл ажиллагаа эрхлэх боломжтой байдаг. Юуны өмнө тухайн агаарын хөлгийн жин нь 15 кг буюу түүнээс бага байх ёстой бөгөөд нислэг зөвхөн өдрийн цагаар, өөрөөр хэлбэл нар мандахаас нар жаргах хүртэл хугацаанд хийгдэх ёстой. Мөн нисгэгч нь дроныг нүдээрээ шууд харж, хянах боломжтой байхаар байрлал эзэлсэн байх, (дэлгэц, дуран, эсвэл ухаалаг утас хамаарахгүй).

Түүнчлэн, хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэх этгээд нь газрын гадаргаас дээш 120 метр (400 фут)-ээс өндөрт нислэг үйлдэхгүй хориотой бөгөөд аэродром дээр, эсхүл түүнээс 4 км дотор үйл ажиллагаа эрхлэхгүй байх үүрэгтэй. Хэрэв тухайн бүс нь хяналттай агаарын зайд хамаарч байгаа бол заавал Нислэгийн хөдөлгөөний удирдлагын байгууллагаас урьдчилан зөвшөөрөл авах ёстой. Дроны нислэгийн явцад бусад хүнтэй агаарын хөлгүүдэд саад учруулахгүй байж, үргэлж зам тавьж өгөх үүрэгтэй бөгөөд тухайн этгээд нь нислэг үйлдэх гэж буй газрын агаарын зайн хязгаарлалт, ангиллыг Монгол улсын нисэхийн мэдээллийн эмхэтгэл (E-AIP) болон ИНД-71 зэрэг баримт бичгүүдээс урьдчилан мэдсэн, ойлгосон байх ёстой.

Мөн нислэг нь нам өндрийн нислэгийн бүс, цэргийн үйл ажиллагааны бүс, аюултай бүсэд хамаарахгүй байх буюу ийм бүсэд үйл ажиллагаа явуулах бол эрх бүхий байгууллагын зөвшөөрөлт авсан байх шаардлагатай. Үүний зэрэгцээ, нислэгийн явцад хүн, өмч хөрөнгөд ямар нэгэн аюул, эрсдэл учруулж болзошгүй нөхцөл байдал үүсэхээс сэргийлж, боломжит бүхий л арга хэмжээг урьдчилан авсан байх үүрэгтэй. Нислэгийн үеэр аливаа эд зүйл хаях, шидэх, тээвэрлэх нь хориотой бөгөөд зөвшөөрөлгүйгээр хүн олноороо төвлөрсөн газрын дээгүүр, нисэх болон хувийн эзэмшлийн газрын дээгүүр нисэх тохиолдолд тухайн иргэн, өмчлөгчөөс урьдчилсан зөвшөөрөл авч ажиллах ёстой. Эцэст нь, техникийн саатал, удирдлага алдагдах зэрэг онцгой нөхцөл байдал үүсвэл дроныг найдвартай, аюулгүй газардуулах зохих арга хэмжээ авсан байх шаардлагатай юм.





НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ

Дээр дурдагдсан үйлчилгээ бүр Аюулын дохио мэдээллийн үйлчилгээ үзүүлэх ба радио холбоотой агаарын хөлөгт нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлнэ. Та онцгой нөхцөлийн туслалцаа /НХҮА-ны нэгжтэй холбоо тогтоогоогүй байсан ч/ хэзээ ч авч болно.Нислэгийн ямар ч үе шатанд туслалцаа хэрэгтэй тохиолдолд бидэнтэй холбогдоорой.

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ нь бүх нислэгийн хөдөлгөөний аюулгүй, дэс дараалалтай байдлыг хангах зорилгоор ажилладаг. Нисгэгч, нислэгийн удирдагчийн хамтын ажиллагааны үр дүнд Монгол Улсад маш сайн нислэгийн хөдөлгөөний удирдлагын стандарт тогтсон. Бид бүх нисгэгч нарт тухайн орон нутгийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын цамхгаар зочилж, нөгөө талаас нь харж үзээрэй гэж санал болгомоор байна.

Зарим тохиолдолд агаарын зайд үүссэн алдаа зөрчлөөс үүдэн цамхаг эсхүл ерөнхий нислэгийн удирдагчтай холбогдож, шалгагдах нь бий. Хамгийн нэн тэргүүний бөгөөд чухал зүйл бол аюулгүй ажиллагаа юм. Агаарын зайг аюулгүй байлгахад бидний хамтын хүчин чармайлт чухал юм.

Монгол Улсад нислэгийн хөдөлгөөний үйлчилгээг Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба /НМЭ ENR 2/ хариуцан үзүүлж байна.



Нислэгийн төлөвлөгөө (Flight Plan)

AERONAUTICAL INFORMATION SERVICE

ICAO Flight Plan

PRIORITY

<<■FF

ADDRESSEE(S)

<<■

FILING TIME

ORIGINATOR

<<■

SPECIFIC IDENTIFICATION OF ADDRESSEE(S) AND / OR ORIGINATOR

3 MESSAGE

<<■ (FPL

7 AIRCRAFT IDENTIFICATION

8 FLIGHT RULES

TYPE OF FLIGHT

<<■

9 NUMBER

TYPE OF AIRCRAFT

WAKE TURBULENCE CATEGORY

10 EQUIPMENT AND CAPABILITIES

<<■

13 DEPARTURE AERODROME

TIME

<<■

15 CRUISING SPEED

LEVEL

ROUTE

<<■

16 DESTINATION AERODROME

TOTAL EET

HR MIN

DEST.ALTN AERODROME

2ND ALTN AERODROME

<<■

18 OTHER INFORMATION

) <<■

19 SUPPLEMENTARY INFORMATION (NOT TO BE TRANSMITTED IN FPL MESSAGES)

ENDURANCE

HR MIN

PERSONS ON BOARD

EMERGENCY RADIO

UHF VHF ELT

SURVIVAL EQUIPMENT

POLAR DESERT MARITIME JUNGLE

JACKETS

LIGHT FLUORES UHF VHF

DINGHIES

NUMBER CAPACITY COVER COLOUR

<< ≡

AIRCRAFT COLOR AND MARKINGS

REMARKS

<< ≡

PILOT-IN-COMMAND

) << ≡

SPACE RESERVED FOR ADDITIONAL REQUIREMENTS

SIGNATURE OF ATS OFFICER	FILED BY	

БУСДЫГ БОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙ

Хүмүүст болон бусдын эд хөрөнгөд хүндэтгэлтэй хандаж, аюулгүйн зайгаа баримтал.

- Нислэгийн төлөвлөлтөө **(Flight Plan)** өгсөн эсэхээ нягтал.
- Олон улсын аэродромын зоонд нисвэл **заавал зөвшөөрөл** авч бай.
- Хүмүүс болон барилга байгууламжаас **аюулгүй зайг баримтал.**
- Хүмүүс зүгээр гэж хэлээгүй л бол **шууд дээгүүр нь бүү нис.**
- Нисгэгч нь зөвшөөрөөгүй л бол **ферм, байшин зэрэг хувийн эдлэн газар дээгүүр бүү нис.**
- Цэцэрлэгт хүрээлэн, наран шарлагын газар, дархан цаазат газар **зэрэг олон нийтийн газар нисэхээсээ өмнө** нутгийн зөвлөл эсвэл Байгаль хамгаалах яамнаас лавла.
- **Өөрийгөө үргэлж харагдахуйц байлга** –Үзэгдэх орчин сайн мөн зөвхөн өдрийн гэрэлд нисэж, – манан, үүлнээс хол байх.
- **Хэрэв та өөр агаарын хөлөг харвал түүнээс сайтар холдож, даруй газард.**





АГААРЫН ЗАЙН ЗУРАГ

Монгол улсын агаарын зайн зургийг ИНҮТ ТӨХХК-аас авах боломжтой бөгөөд хуулбарыг үнэ төлбөргүйгээр авахыг www.ais.mn хаягаар аваарай.

Радио холбооны үг хэллэг

Нисгэгч, нислэгийн удирдагч хоорондын радио холбооны гарын авлагыг хэдэнтээ дурдсан билээ. Тод, ойлгомжтой, зөв радио холбооны үг хэллэг хэрэглэх нь радио холбоонд чухал.

Радио холбооны загварчилсан хэллэгийн талаар Зөвлөмжийн цуврал AC 91-9 Radiotelephony Manual-ийг үзнэ үү! (www.mcaa.gov.mn/file/693)


Иргэний нисэхийн хууль тогтоомж
“Civil Aviation Act”
ОУИНБ
“ICAO”
Агаарын зайн хууль тогтоомж
“Airspace Act”
Нислэгийн үйл ажиллагаа
“Flight Operations”
103
104
149
106
105
Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээжүүлэлт
“Certification Airworthiness”
26
39
21
146
148
Агаарын хөлгийн бүртгэл
“Aircraft Registration”
47
125
121
135
119
115
129
91
102
137
92
133
Нислэгийн хөдөлгөөний удирдлагын тогтолцоо
“Air Traffic Managment System”
139
175
174
171
173
172
141
67
65
Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэжжүүлэлт
“ATC Licensing”
НТЧ хадгалалтын гэрчилгээжүүлэлт
“Continuing Licensing”
145
43
66
147
Агаарын хөлгийн техник үйлчилгээний инженерийн
“AME Licensing”
141
21
67
63
Нисэх багийн үнэмлэжжүүлэлт
“Flight Crew Licensing”

Administrative Matters	
Иргэний нисэхийн тухай хууль	Civil Aviation Act
Агаарын зайн тухай хуулын	ANSpace ACE
ИНД-ийн нэр томьёоны тайлбар	Part Difinition and Abbreviations
ИНД-12 Осол, зөрчил болон статистик мэдээлэл	Part 12 Accidents, Incidents, and Statistics Procedure
ИНД-13 Зөрчлийг шалгах	Part 13 Enforcement Procedures
ИНД-100 Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо	Part 100 Safety Management System
AAI Rule Aircraft Accident Investigation Rule	AAI Rule Aircraft Accident Investigation Rule
Certification / Airworthiness	
ИНД-21 Бүтээгдэхүүн, зэд ангийн гэрчилгээжүүлэлт	Part 21 Certification of Products and Parts
ИНД-26 Нислэгт тэнцэх чадварын нэмэлт шаардлага	Part 26 Additional Airworthiness Requirements
ИНД-39 Нислэгт тэнцэх чадварын удирдамж	Part 39 Airworthiness Directives
ИНД-146 Агаарын хөлөг зохион бүтээх байгууллагын гэрчилгээжүүлэлт	Part 146 Aircraft Design Organisations – Certification
ИНД-148 Агаарын хөлөг үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээжүүлэлт	Part 148 Aircraft Manufacturing Organisations – Certification
Aircraft Registration	
ИНД-47 Агаарын хөлгийн бүртгэл	Part 47 Aircraft Registration and Marking
Continuing Airworthiness	
ИНД-43 Техник үйлчилгээний ерөнхий дүрэм	Part 43 General Maintenance Rules
ИНД-145 Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт	Part 145 Aircraft Maintenance Organisations – Certification
Aircraft Maintenance Engineer (AME) Licensing	
ИНД-66 Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэх	Part 66 Aircraft Maintenance Personnel Licensing
ИНД-147 Нисэхийн техник үйлчилгээний сургалтын байгууллагын гэрчилгээжүүлэлт	Part 147 Aviation Maintenance Training Organisations – Certification
Flight Operations	
ИНД-91 Нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм	Part 91 General Operating and Flight Rules
ИНД-92 Аюултай бараа тээвэрлэх	Part 92 Carriage of Dangerous Goods
ИНД-102 Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлт	Part 102 Unmanned Aircraft Operator Certification
ИНД-103 Хэт хөнгөн агаарын хөлгийн үйл ажиллагааны дүрэм	Part 103 Microlight Aircraft – Operating Rules
ИНД-104 Глайдерын үйл ажиллагааны дүрэм	Part 104 Gliders – Operating Rule
ИНД-105 Шүхрийн үйл ажиллагааны дүрэм	Part 105 Parachuting – Operating Rules
ИНД-106 Ханг-глайдерын үйл ажиллагааны дүрэм	Part 106 Hang Gliders –Operating Rules
ИНД-115 Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлт	Part 115 Adventure Aviation – Certification
ИНД-119 Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт	Part 119 Air Operator – Certification
ИНД-121 Том нисэх онгоцны арилжааны нислэгийн үйл ажиллагаа	Part 121 Air Operations –Large Aeroplanes
ИНД-125 Дунд нисэх онгоцны арилжааны нислэгийн үйл ажиллагаа	Part 125 Air Operations –Medium Aeroplanes
ИНД-129 Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт	Part 129 Foreign Air Transport Operator – Certification
ИНД-133 Нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа	Part 133 Helicopter External Load Operations
ИНД-135 Нисдэг тэрэг болон жижиг нисэх онгоцны арилжааны нислэгийн үйл ажиллагаа	Part 135 Air Operations –Helicopters and Small Aeroplanes
ИНД-137 Хөдөө аж ахуйн агаарын хөлгийн үйл ажиллагаа	Part 137 Agricultural Aircraft Operations
ИНД-149 Нисэх клубийн гэрчилгээжүүлэлт	Part 149 Aviation Recreation Organisations –Certification
Flight Crew Licensing	
ИНД-61 Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл	Part 61 Pilot Licences and Ratings
ИНД-67 Эрүүл мэндийн стандарт болон гэрчилгээ	Part 67 Medical Standards and Certification
ИНД-141 Нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээжүүлэлт	Part 141 Aviation Training Organisations –Certification
Air Traftic Management Systems	
ИНД-139 Аэродромын үйл ажиллага, гэрчилгээжүүлэлт	Part 139 Aerodromes – Certification and Operation
ИНД-171 Агаарын навигацийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт	Part 171 Aeronautical Telecommunication Services – Certification
ИНД-172 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт	Part 172 Air Traffic Service Organisations – Certification
ИНД-173 Хэрэглээлийн нислэгийн журмын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт	Part 173 Instrument Flight Procedure Service Organisation – Certification
ИНД-174 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт	Part 174 Aviation Meteorological Service Organisations –Certification
ИНД-175 Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт	Part 175 Aeronautical Information Services Organisations – Certification
Air Traffic Controller (ATC) Likensing	
ИНД-65 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтны үнэмлэх, зэрэглэл	Part 65 Air Traffic Service Personnel Licences and Ratings
ИНД-67 Эрүүл мэндийн стандарт болон гэрчилгээ	Part 67 Medical Standards and Certification
ИНД-141 Нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээжүүлэлт	Part 141 Aviation Training Organisations –Certification


Controlled Airspace
Class A
Class C
Airspace Requirements
IFR
VFR
Aircraft Radio Required
Entry Clearance Required
ATC Separation Provided
Traffic Information Provided
Speed Limitations
VFR Visibility Minima
VFR Distance from Cloud Minima
118.30
STOP
(Below 5 km visibility)
At or above 3000 m AMSL
8 Km
Below
5 Km
2 km
Horizontally
300 m*
*(150 m within a control zone)
Vertically (aboveor below)
Below 3000 m – 460 km/h max



Special Use Airspace

Authorisation Required



- Military exercises – including live firing
- Enter only after authorisation from the administering authority, if:

– a Mongolian registered aircraft; or

– any other aircraft within Mongolian territory

= IFR	= VFR
= SVFR	= ATC Service
= Flight Information Service	= Aircraft Radio Required
= Entry Clearance Required	= ATC Separation Provided
= Traffic Information Provided	= Visibility

G

VFR minima at aerodromes in uncontrolled airspace *(CAR Part 91)*

	CELING	VISIBILITY
DAY	200 m	1500 m
NIGHT	450 m	8000 m

C **D**

VFR minima at aerodromes within a control zone (CAR Part 91)

	CELING	VISIBILITY
DAY	450 m	5000 m
NIGHT	450 m	5000 m

ХҮНИЙ ХҮЧИН ЗҮЙЛ
HUMAN FACTOR



Аюултай хандлага Hazardous Attitude	Засах арга Antidote
Дур зоргоороо аашлах Anti-Authority “Надад юу хийхийг битгий заа” “Don’t tell me what to do”	Дурмээ дага - Дүэм ихэнхдээ зөв байдан Follow the rules- they are usually right
Түргэн зан Anti-Authority “Юу ч хамаагүй, хурдан л хийе” “Do something quickly”	Битгий яар, эхлээд бод Anti-Authority
Хэнэггүй байдал Invulnerability “Энэ надад тохиолдохгүй ээ” “It won’t happen to me”	Энэ надад ч бас тохиолдож болно it could happen to me
Сагсуу эр Macko “Би бүгдийг чадна” “I can do it”	Азаа сорих нь тэнэглэл Taking chances is foolish
Хэнэггүй байдал Invulnerability “Миний хэрэг байхгүй дээ” “What’s the use”	Би чинь хэрэггүй амьтан биш. Би илүү сайн хийж чадна I am not helpless. i can make a difference



НИСЛЭГИЙН ӨМНӨХ ШАЛГАХ ХУУДАС
Cross-Country Checklist

- ☐ НИСЛЭГТ ГАРАХАД БЭЛЭН ҮҮ?
  Fit to fly? (I'm Safe)
- ☐ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙДАЛ?
  Medical current?
- ☐ ХОЁР ЖИЛИЙН НИСЛЭГИЙН ДҮГНЭЛТ?
  Biennial flight review (BFR) current?
- ☐ МАЯГЫН ЗӨВШӨӨРӨЛ?
  Current on type?
- ☐ ЦАГ АГААР?
  Checked weather?
- ☐ НИСЛЭГИЙН ЖУРАМ?
  Current charts?
- ☐ АИП-ТАЙ ТАНИЛЦСАН?
  Current AIP?
- ☐ АИП-ИЙН НЭМЭЛТ?
  Checked AIP Supplements?
- ☐ НОТАМ-ТАЙ ТАНИЛЦСАН УУ?
  Checked NOTAMs?
- ☐ НИСЛЭГИЙН БҮРТГЭЛ?
  Prepared flight log?
- ☐ АГААРЫН ХӨЛГИЙН ТЕХНИКИЙН БҮРТГЭЛ?
  Aircraft tech log checked?
- ☐ НИСЛЭГИЙН ӨМНӨХ АГААРЫН ХӨЛГИЙН БЭЛЭН БАЙДАЛ, СУМАЛГАА?
  Aircraft pre-flighted and fuelled (clean windscreen)?
- ☐ ТҮЛШ, ТОСНЫ НӨӨЦ?
  Fuel card and spare oil?
- ☐ АГААРЫН ХӨЛГИЙН ЖИН БОЛОН ТЭНЦВЭР?
  Aircraft weight and balance within limits?
- ☐ БЭХЭЛГЭЭ?
  Pickets securely stowed?
- ☐ ЗАЙЛШГҮЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ ХЭРЭГСЭЛ?
  Safety equipment (eg, first aid kit, life jackets, cellphone)?
- ☐ ОНЦГОЙ НӨХЦӨЛД ХЭРГЭЛЭХ ЭД ЗҮЙЛС?
  Survival kit, warm clothing, food and water cansidered?
- ☐ ЗОРЧИГДОД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ?
  Passenger briefed and visited the toilet?
- ☐ НИСЛЭГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ?
  Flight plan filed?
- ☐ НИСЛЭГТ ЗӨВШӨӨРӨЛ?
  Flight authorised?




14:15
14:45
32
200905 ZMUBYNYX
(A1122/14 NOTAMN
Q) ZMUB/QMRLC/IV/NBO/A/000/999/4751N10646E005
A) ZMUB B) 2006150230 C) 2006150500
E) RWY 14/32 CLSD DUE WIP ON NORTHERN RWY EDGE
AVBL FOR SKED OPS AND APPROVED OPERATORS WITH
2 HOURS PN CONTACT AIRPORT MANAGER
TEL +976-7128-XXXX)
Check NOTAMs
and AIP Supps
Rev.0. 12 Feb 2020
www.mcaa.gov.mn